МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2025.06.17 № 01/1480

танай______________-ны №______________-т

АЙМАГ, ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА НАРТ

Төсвийн хуваарь хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн "Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай" А/154, "Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай" А/161 дүгээр тушаалыг тус тус хүргүүлж байна. Эдгээр тушаалаар нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын аймаг, дүүргийн болон аймаг, дүүргийн 2025 оны төсвийн сар, улирлын хуваарьт дараах зохицуулалтыг хийсэн болно. Үүнд:

1.Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх зарцуулагдаагүй үлдэгдлийг 2025 оны 12 дугаар сар руу шилжүүлсэн;

2.Тэтгэврийн, тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгалын сангийн зарлагын төсвийн аймаг, дүүргийн болон аймаг, дүүргийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулсан;

3.Нийгмийн даатгалын сангаас санхүүжих ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээний зардлын төсвийн аймаг, дүүргийн хооронд болон аймаг дүүргийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан зохицуулалт хийсэн зэрэг болно.

Иймд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасныг баримтлан төсвийн сахилга батыг хангаж ажиллахыг мэдэгдье.

ДАРГА Б.БАТЖАРГАЛ

15 5001537

